



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/1499

Алтай хот

“Алтайн залуус-2022” Жаргалан сумын
малчин залуучуудын чуулган, арга
хэмжээ зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 10.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалт, Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1.Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор “Алтайн залуус-2022” Жаргалан сумын малчин залуучуудын чуулган, арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулж, шаардагдах зардлыг хэвсрэлтаар баталсугай.

2.Шаардагдах 6,453,000 (зургаан сая дөрвөн зуун тавин гурван мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА


САМГАЛАНБААТАР



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201091544

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 1199 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Цайны завсарлага, өглөөний цай-2 удаа Үдийн хоол-2 удаа Оройн хоол-2 удаа	13	68,000	884,000
2.	Жаргалан-Алтай хот-Дөргөн нуур-Жаргалан ирж очих автомашинны шатахууны зардал (2 талдаа нийт 550 км)	1 автомашин	369,000	369,000
3.	Жуулчны баазын төлбөр	1 гэр*2 өдөр	100,000	200,000
4.	Тайз, ширээ сандал, гэрэлтүүлэг, хөгжим аппартур, тээвэрлэлтийн зардал	5 автомашин	1,000,000	5,000,000
Нийт зардал				6,453,000

__оОо__